



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар A/7

Улаанбаатар хот

Гишүүнчлэлийн жилийн хөлс хөнгөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, Гишүүнчлэлийн журмын 3.3.2, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын хөрөнгийн биржийн 2018 оны үнэт цаасны арилжааны нийт үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн Монголын хөрөнгийн биржийн гишүүн “хавсралт-1”-д нэр дурдсан 6 үнэт цаасны компанид 2019 оны гишүүнчлэлийн жилийн хөлсөөс тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлсүгэй.
2. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн “хавсралт-2”-т нэр дурдсан 43 Гишүүн үнэт цаасны компанид 2019 оны гишүүнчлэлийн жилийн хөлсөөс тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлсүгэй.
3. Монголын хөрөнгийн биржийн 2019 оны гишүүнчлэлийн жилийн хөлсийг хөнгөлсөн дүнгээр тооцож нэхэмжлэхийг Санхүүгийн алба /П.Болормаа/-нд даалгасугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавих, гишүүн компаниудад мэдэгдэх ажлыг Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000007

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2019 оны 1-р сарын ³¹...-ний өдрийн
A/7... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Д/д	Гишүүн ҮЦК-ийн нэрс	Нийт арилжааны үнийн дүн	Эзлэх хувь
1	"Голомт капитал ҮЦК" ХХК	194,959,607,637.82	39.9%
2	"Ти ди би капитал ҮЦК" ХХК	71,583,559,504.49	14.7%
3	"Мирэ эссэт секьюритис монгол ҮЦК" ХХК	58,233,086,525.08	11.9%
4	"Би ди сек үцк" ХК	39,510,233,867.50	8.1%
5	"Новел инвестмент ҮЦК" ХХК	28,210,906,684.81	5.8%
6	"Бумбат-Алтай ҮЦК" ХХК	24,578,030,927.96	5.0%

-----oOo-----

